



**НИЙСЛЭЛИЙН
АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2017. оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/09

Улаанбаатар хот

Эд хөрөнгийн тооллого хийх комисс
байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70, 71, 72 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай Хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2 дугаар заалтуудыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Байгууллагын хагас жилийн үндсэн хөрөнгө болон хангамжийн хөрөнгийн тооллогыг зохион байгуулж явуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үүнд:

Тооллогын комиссын дарга: О.Мягмарсүрэн /Захиргааны хэлтсийн дарга/
Гишүүд: О.Алтангэрэл /авто тээврээс үүдэлтэй агаарын
бохирдол хариуцсан ахлах мэргэжилтэн/

М.Отгонбаяр /орчны хэмжилт хариуцсан
мэргэжилтэн/

С.Марта /түлшний бодлого зохицуулалт
хариуцсан мэргэжилтэн/

Нарийн бичгийн дарга: Ү.Одонбилэг /худалдан авах ажиллагаа
хариуцсан мэргэжилтэн/

2. Эд хөрөнгийн тооллогыг 2017-06-19-ны өдрөөс 2017-06-30-ны хооронд чанартай, үнэн зөв, зохион байгуулаж, илтгэх хуудаст тусган 2017 оны 07 дугаар сарын 03 дотор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйл **Эд хөрөнгийн тооллого явуулах журамд заасны дагуу** танилцуулахыг комиссын дарга /О.Мягмарсүрэн/-д үүрэг болгосугай.

3. Эд хөрөнгийн тооллогыг явуулаж зохион байгуулах төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

4. Тооллогоор цаашид ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийн жагсаалтыг гаргаж холбогдох баримтыг бүрдүүлэн НӨХГ-аар дүгнэлт гаргуулах, хангамжийн хөрөнгийг өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт гаргуулан шийдвэрлүүлэхийг тооллогын комиссын дарга /О.Мягмарсүрэн/, өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга /Д.Жаргалсайхан/-д тус тус даалгасугай.

ДАРГА



М.ДЭЛГЭРЭХ